



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/164


Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1./а/, 29.1.1./е/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит IX хуралдааны 9/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Татварын бааз суурь өргөжүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сургалт, сурталчилгаа зохион байгуулахыг Татварын хэлтэс /н.Өлзийсайхан/-т даалгасугай.

2.Тус ажлыг зохион байгуулахад шаардагдах 15 000 000 /арван таван сая/ төгрөгийн зардлыг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын бусад зардлын Татварын бааз суурийг өргөжүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сургалт сурталчилгааны зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны
3 дугаар сарын 27-ны өдрийн
1167 дугаар захирамжийн хавсралт

ТАТВАРЫН БААЗ СУУРЬ ӨРГӨЖҮҮЛЭХ, ТАТВАРЫН ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ, СУРГАЛТ,
СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг/
1	Телевизийн нэвтрүүлэг, татварын хууль тогтоомжийг сурталчилах, татварын сэдэвт рекламьг бэлтгэн телевиз, FM радиогоор явуулах	Тоо	12	300 000	3 600 000
2	Хууль сурталчилах ажлын хүрээнд 8 төрлийн хуулийн сурталчилгааны материал, санамж танилцуулга болон бусад эхийг бэлтгэж хэвлүүлэх	Тоо	10 000	800	8 000 000
3	Хуулийн хэрэгжилтийг хангуулах, сургалт, сурталчилгаатай холбоотой бичиг хэргийн зардал /Бичгийн цаас, принтерийн хор, бусад бичгийн хэрэгсэл/	Тоо	1	1 965 000	1 965 000
4	ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх иргэдийн тайлангийн ТТ-06а, 065 маягт, ТБ-03, ТТ-14 маягт хэвлүүлэх	Ширхэг	14 000	70	980 000
5	ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх иргэдийн бүрдүүлэх материалын жагсаалт, хүсэлт хэвлүүлэх	Ширхэг	9 100	50	455 000
					15 000 000